



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

**“Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн
хэмжээг тооцох аргачлал” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.2, Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. ”Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН ХЭМЖЭЭ, ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 7.2 дахь заалт болон 14.2.5-д заасан даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцоход энэхүү аргачлалыг мөрдлөг болгоно.

~~1.2. Энэхүү аргачлалын давтамж цөөтэй буюу даатгалын нэг удаагийн тохиолдлоор их хэмжээний хохирол гардаг даатгалын хураамжийг тооцоход ашиглана. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор хассан/~~

ХОЁР. ДААТГАЛЫН ХЭМЖЭЭ

2.1. Даатгалын хэмжээ гэж даатгалын хураамж тооцох, эсвэл даатгалын тохиолдол болоход даатгагчаас даатгуулагчид төлөх нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход үндэслэл болгож байгаа зүйлийн бодит үнэ цэнийг хэлнэ.

2.2. Даатгалын хэмжээг Монгол Улсын Иргэний хуулийн 438.1 дүгээр заалтын дагуу даатгагч, даатгуулагч нар харилцан тохиролцож тогтооно.

ГУРАВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

3.1. Даатгалын хураамжийн хэмжээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- 3.1.1. Даатгалын цэвэр хураамж;
- 3.1.2. Даатгалын нэмэлт хураамж.

3.2. Даатгалын цэвэр хураамжаар даатгалын хохирлыг нөхөн төлөхөд зарцуулах нөөцийн санг бүрдүүлнэ.

3.3. Даатгалын нэмэлт хураамжид даатгалын үндсэн үйл ажиллагааны зардлууд болон даатгагчийн хариуцах даатгалын зуучлагч, төлөөлөгчийн шимтгэл, татвар хураамжууд багтана.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ

4.1. Даатгалын хураамжийн хэмжээг тогтооход дараах зарчмыг баримтлана:

4.1.1. Даатгалын хураамжийн хэмжээ нь даатгагч, даатгуулагчийн эрх, ашигт нийцсэн байх;

4.1.2. Хохирлыг төлөхөд хүрэлцээтэй байх;

4.1.3. Даатгалын үйл ажиллагаа явуулахад даатгагчийн зардлыг нөхөхүйц байх;

4.1.4. Даатгалын хураамжийн хэмжээ нь харьцангуй тогтвортой байх.

4.1.5. Даатгалын бүтээгдэхүүний эрсдэлд нөлөөлөх томоохон хүчин зүйлсийг тусгасан байх;[/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/](#)

4.2. Даатгалын хураамжийн хэмжээг дараах байдлаар тооцно:

олгосон нөхөн олговор + олгохоор тооцсон нөхөн олговрын нөөц _____
а/ Дундаж нөхөн олговор (ДНО) = -----

_____ нэхэмжилсэн нөхөн + учирсан боловч тайлагнагдаагүй
олговрын тоо нэхэмжлэлийн тоо _____

_____ тайлагнагдсан нэхэмжлэлийн + учирсан боловч тайлагнагдаагүй
тоо нэхэмжлэлийн тоо _____

б/ Хохирлын давтамж (ХД) = -----

нийт даатгалын гэрээний тоо [/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор хассан/](#);

4.2.1. Даатгалын хураамжийн хэмжээг тооцоход ашиглах мэдээллийг даатгагч, даатгалын салбарын болон бусад улсын ижил төстэй мэдээлэлд үндэслэн боловсруулна;[/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#);

4.2.2. Даатгалын хураамжийн хэмжээг тооцоход ашиглах оновчтой актуар аргачлалуудыг сонгоно;[/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#);

4.2.3. Энэхүү аргачлалын 4.2.1-д заасан мэдээллийг үндэслэн хураамжийн хувь хэмжээг тогтооно;[/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#);

4.2.4. Нэмэлт хураамжид даатгагчийн үйл ажиллагааны зардал болон ашгийг оруулан тооцно;[/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#);

ТАВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ БАТАЛГААЖУУЛАХ

5.1. Хороо даатгагчаас ирүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцсон тооцооллыг ажлын 15 хоногийн дотор хянана;[/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#);

5.2. Даатгалын хураамжийн хэмжээг тогтоосон материалыг баталгаажуулахад дараах шаардлагыг тавина:

5.2.1. Даатгалын хураамжийн тооцоог эрх бүхий актуарчаар хийлгэх;[/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#);

5.2.2. Энэ журмын 5.2.1-д заасан судалгаанд ашигласан мэдээллийн бодит үнэнийг холбогдох байгууллагаас авсан баримтаар баталгаажуулсан байх.

ЗУРГАА. БУСАД

6.1. Даатгалын хураамжийн хэмжээг эрсдэлд өртөж болзошгүй объект, өртөх магадлал, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр ялгавартай тооцож болно.

6.2. 2 жил болон түүнээс дээш хугацаанд гардаг, даатгалын тохиолдол ньолон давтамжтай болдог даатгалын төрлийн хувьд даатгалын хураамжийн хэмжээг тухайн давтамжийн жилийн тоонд хувааж, жилийн даатгалын хураамжийн хэмжээг тооцож болно.

6.3. Эрсдэл тус бүрээр учирч болох хохирлын судалгааг 3-аас доошгүй жилийн статистик мэдээг ашиглажхийнэ.

~~6.4. Даатгагч даатгалын хураамжийн хэмжээг өөр аргачлалаар тооцохоор болсон тохиолдолд энэ талаар Хороонд мэдэгдэнэ.~~[/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 347 дугаар тогтоолоор хассан/](#);

6.5. Хороо даатгагчийн сонгосон аргачлалыг шаардлага хангахгүй гэж үзвэл энэ тухай тайлбар, үндэслэлийг албан бичгээр даатгагчид хүргүүлнэ.

6.6. Энэ журмын 6.5-д заасан тайлбар үндэслэлийн дагуу шаардлага хангасан аргачлал хэрэглээгүй тохиолдолд Хорооноос Даатгалын тухай хуулийн 83.1.32-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.